

**Анхдугаар Үндсэн хууль ба түүний улс төрийн
шийдвэр дагалдсан хууль зүйн аналитик**

**The First Constitution and the Legal Analysis
Accompanying its Political Decision**

Шарын Цогтоо

Хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

Монгол Улсын Их Сургуулийн

Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор,

Улаанбаатар, Монгол Улс.

tsogtoo@num.edu.mn



[Товч утга]

Үндсэн хууль бол улс төр судлал, хэл шинжлэл, философи, түүх судлал, математик зэрэг хэд хэдэн шинжлэх ухааны нийлмэл цогц дээр тайлбарлагддаг өвөрмөц судлагдахуун гэдгийг онцлох нь зүйтэй. Энэ лугаа адил анхдугаар Үндсэн хуулийн эрх зүйн үр дагаврыг хөндөхөд мөн л социалист, феодалист, автократ, тоталитар улс төрийн дэглэм, ардчиллын болон либериал үзэл санааны зөрчилдөөний учрыг нь олох шаардлагатай тулгардгийг анхаарвал зохино. XX зууны эхээр 1911 онд Чин улс, 1917 онд хаант Орос гэсэн хоёр том импери задран унаснаар үндэстнийхээ хувьд мөхөл сэхлийн ирмэг дээр тогтож ядаж байсан монголчуудад тусгаар тогтнолоо дахин сэргээх боломж олдсон юм. Тодорхой хэлбэл 1921-1924 онд залуу ЗХУ, коментерний хяналт зааварчилга дор монголчууд анхны Үндсэн хуулиа баталж, БНМАУ-ыг зарлан тунхагласан нь өнөөгийн ардчилсан монгол улсын залгамж холбоо болж тэр үеийн түүхэн ач холбогдол одоо ч алдагдаагүй хэвээр байна.

Ардчилсан улс төрийн дэглэмийн критери шалгуур талаас нь үзвэл Монгол Улсын 1924-1960 оны Үндсэн хуульд тусгагдсан улс төрийн сонгох ба сонгогдох эрх нь нэгэнт тогтсон нэг намын тогтолцоон дахь бүх нийтийн санал хураалтын шинж чанартай байсан бөгөөд иргэд өөр өөрсдийн улс төрийн чиг баримжааны жинхэнэ сонголт хийж чаддаггүй байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Харин 1992 оны шинэ Үндсэн хуулийг хэрэглээний хувьд улс төрийн ардчилсан дэглэмд суурилсан удирдлага зохион байгуулалтыг төлөвшүүлэхийн төлөөх үйл ажиллагаа байсан болохыг тус хууль зүйн аналитикаар дүгнэхийг оролдлоо.

[Түлхүүр үг]

Төр, Улс, Ардчилсан Улс Төрийн Дэглэм, Либерализм, Неолиберализм, “Идеологи”, “Идеал”, “*De facto*” “*De jure*” үйл явц, “ах дүү” Үндсэн хуулиуд, Үндсэн хуулиудын зөрчилдөөнт байдал.

I. Оршил хэсэг буюу Монгол Улсын анхдугаар Үндсэн хууль батлагдахын өмнөх түүхэн нөхцөл байдал

Юуны урьд Үндсэн хууль бол улс төр судлал, хэл шинжлэл, философи, түүх судлал, математик зэрэг хэд хэдэн шинжлэх ухааны нийлмэл цогц дээр тайлбарлагддаг өвөрмөц судлагдахуун гэдгийг онцлох нь зүйтэй. Энэ лугаа адил анхдугаар Үндсэн хуулийн эрх зүйн үр дагаврыг хөндөхөд мөн л социалист, феодалист, автократ, тоталитар улс төрийн дэглэм, ардчиллын болон либерал үзэл санааны зөрчилдөөний учрыг нь олох шаардлагатай тулгардгийг анхаарвал зохино.

Оросоор “конституция”, англиар “constitution” гэх нэр томъёогоор илэрхийлдэг уг шинжлэх ухаанч суурь судлалын гол араг яс нь Хууль тогтоох эрх мэдэл, Гүйцэтгэх эрх мэдэл, Шүүх эрх мэдэл гурав мөн тул Үндсэн хуулийн анхны үзэл санаа монголд 1911 оны Олноо өргөгдсөн Монгол Улсын таван яам, дээд доод хоёр хурлаас эхлэлтэй гэж үзэж болно¹.

XIX-XX зууны Монголын үндэсний эрх чөлөөний төлөө тэмцлийг батлах тоо баримт, улс төрийн шийдвэрийг Б.Чимид багшийнхаа заасан ёсоор өнгөрсөн, одоо, ирээдүй цаг тооллын харилцан хамааралд авч үзэхийг чадан ядан хичээснээ энэхүү сэдэв дор товч толилуулъя.

XIII зуунд эзэнт гүрэн байсан Чингис хааны төрт улс яагаад бага буурай үндэстэн ястны тоонд ортлоо доройтсон бэ? гэдэг асуудлын эргэн тойрон дахь гол шалтгааны дотор чухамдаа түүнийг залгамжилж яваа үе үеийн монгол ноёд, дарга даамлууд сагсуу ойворгон, залхуу хойрго, ноён урваач нохой шарваач, зугаа цэнгэл, бялдуучлал, задрал бутрал, авлигал хээл хахуульд идэгдэн идэгдсээр XV-XVII зуунд яс угшил, нутаг нугаараа талцсан засаг захиргаа-нутаг дэвсгэрийн эмх замбараагүйтэл одоо ч гэсэн өнгө зүсээ хувирган үргэлжилж Чингис хааны эзэнт гүрэн байгуулагдахаас өмнөх шиг олон овог аймгийн нэг жижигхэн үгээгүй ядуу хэсэг болж үлдсэн халх монголын ноёд баядууд ард түмнийхээ нуруунд 220 гаруй жилийн туршид зовлон зүдгүүр үүрүүлсэн гашуун сургамжийг өгүүлдэг.²

- Монголчууд 1691 он гэхэд Манж Чин улсын эрхшээлд орсноор

¹ Үүнийг судлаач Цэвээн Жамсранов, доктор (Sc.D), профессор З.Лонжид, О.Батсайхан, Ж.Цэцэгмаа, доктор (Ph.D) Б.Батбаяр (“Монгол Улсын хууль зүйлийн бичиг монголын анхны төрөлжүүлсэн (кодификац) хууль болох нь”) нарын бүтээлүүдийг харьцуулан үзэхийг зөвлөө.

² З.Лонжид, Т.Лхагваа. Тусгаар тогтнол ба Монгол Улс дахь анхны нийгэм эдийн засгийн шинэтгэл: Ерөнхий сайд Ц.Жигжиджавын гүйцэтгэсэн түүхэн үүрэг. Уб., 2021 он. х 14-33 дахь тал.

тухайн тэр үедээ өөртөө хадгалагдаж байсан хагас боловч тусгаар эрхт байдлаа алдсантай шууд холбоотойгоор Халх монголын уугуул нутгийг “гадаад монгол” гэх нэр оноож, Чин гүрний захиргаанд хамааруулсан байдаг (1691-1911 он).

- XX зууны эхээр 1912 онд Манж Чин улс, 1917 онд Оросын хаант засаг гэсэн хоёр том улс задран унаснаар Монголд үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэл өрнөх боломж олдсон хэрэг. Түүнээс биш үгээгүй ядуу, зэр зэвсэггүй, өвгөд, хөгшид, эмэгтэйчүүд, хүүхэд багачууд нэжгээд таван зуугаадхан мянган цөөн хүн амтай монголчууд гадаадын колоничлогчид болон дотоодын сорон мөлжигч баячуудын эсрэг тэмцэн босож ардын хувьсгал мандуулсан гэвэл үнэнд үл нийцнэ. Харин залуу ЗХУ-ын нөлөөгөөр 1921-1924 онд БНМАУ-ыг зарлан тунхаглаж, анхны Үндсэн хуулиа баталсан нь өнөөгийн ардчилсан Монгол Улсын залгамж холбоо болсон түүхтэй. Харамсалтай нь одоо ч гэсэн Монгол Улс хөрш Оросоос эрчим хүч, барилга байгууламж, аж үйлдвэрлэлийн цөөнгүй эх үүсвэр, хөрш хятадаас түүхий эдийн зах зээлийн хувьд маш их (ойролцоогоор 80%) хамааралтайгаар 100 гаруй жилийн нүүрийг үзжээ. Орос, Монгол, Хятад гурвуулаа автократ буюу авторитар, тоталитар дэглэмийн түүхэн замналтай³ ч сүүлийн 30 гаруй жилд ардчилал зах зээл нэр дор найрсаг харилцаатай түншүүд болон хамтарч буй онцлогтой.

Залуу Монгол Улс 1915 оноос эхлэн колони, хагас колони “де факто” оронд тохиолддог элдэв саад тотгор, зовлон зүдгүүр, “БЭТ” буюу комментерний “Бүрэн эрхт төлөөлөгч”-ийн цэрэгжсэн дарангуйллыг тэвчиж сая нэг юм 1946 онд хоёр хөрш ээлж дараалан элчин сайд томилж, ЭСЯ байгуулснаар жинхэнэ бүрэн эрхт тусгаар тогтносон “де юре” Монгол Улс дипломат хэв хууль, ёс жаягаар ажиллаж эхэлсэн байдаг. Энэ бол 1946 он хүртэлх цаг хугацаанд үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэл үргэлжилж, түмэн бэрхшээлийг даван туулсны эцэст дэлхийн 2-р дайны дараа Ялтын гэрээний үр дүнд манай тусгаар тогтнол бусад улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн гэсэн үг⁴. Товчдоо бол 1911 оноос 1946 он хүртэлх 35 жил бүхэлдээ эх оронч өвөг дээдэс маань ДИУ, ЗСБНХУ-ын дарлал колоничлол, японы нөлөөний Манж Го улсын өдөөн хатгалгыг чадан ядан тэсвэрлэсэн Үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэлд ядарсан, ядуурсан, доройтсон,

³ Оливер Корфф, Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн түүхийн товчоон. Уб., 2024.

⁴ Манай 1924, 1940 оны Үндсэн хуульд эх үүсвэр нь байгаа гэж хэлж болох “БЭТ” гэгч коммунист үзэл сурталыг баримтлагч хүчирхийлэл, дарангуйлал, аллага хядлага дагуулсан энэ увайгүй үзэгдэл одоо ч гэсэн хэлбэр дүрсээ хувиргах төдийд 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн үзэл санааг ухамсаргүйгээр ашиглан хоёрхон жилийн өмнө Өмнөговийн бага таван толгойн хувийн өмчийн нүүрсний уурхай дээр ЗГ-аас томилсон БЭТ-ийн “балмад” ажиллагаа ардчилалд хэтэрхий хари буйг үгээр хэлэх ч юм биш (Ш.Ц).

алуулж хядуулсан хүнд хэцүү он жилүүд байсан.⁵

Үүнээс хойш олон жилийн дараа 1989 онд манай гурван том хөршийн хоёр нь буюу Жорж Буш, Дэн Сяопин нар Бээжинд уулзахад гурван сая хавтгай дөрвөлжин км нутаг Оросын мэдэлд байгаа талаар хөндөгдсөний нэг нь гадаад монголын 1.5 сая хавтгай дөрвөлжин км, нөгөө нь Амар мөрний хойд талаас одоогийн алс дорнодод хамаарах бас нэг 1.5 сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэрийг хэлж буй санаа юм. Хятадын сошиалыг харж байхад 1836 онд эхэлсэн опиумын I, II дайнаар дэлхийн 5 их гүрэнд алдсан Макао (Португал), Чиндао порт (Герман), Хонг Гонг (Англи), Далиан (Орос), Манжуур (Япон) эх улсдаа буцаж ирчихээд байхад цаана нь хоёр ч маргаантай бүс үлдсэний нэг нь “гадаад монгол” болж таардаг. Жорж Буш, Дэн Сяопин хоёрын уулзалтын дараахан мөн тэр оны, тэр сард ЗХУ-ын ГХЯ-ны сайд асан Э. Шевардназе, Ерөнхийлөгч М.С. Горбачев нарын цуварсан уулзалт болж ЗХУ цэргээ БНМАУ-аас гаргахаар шийдвэрлэсэн байдаг.

Ийнхүү дэлхийн I дайны дараа ЗХУ байгуулагдсанаар шинэ Монгол Улс үүсэх нөхцөл бүрдсэн бол 1920-оод оноос коммунист нэг намын ноёрхол бүхий ЗСБНХУ-тай нягт холбоотой байсан зэргээс үүдэн монгол сталинист терроризмын золиос болсон нь түүхэн үнэн. Гэхдээ Монголд өөр сонголт бараг байгаагүй гэж хэлж болно. Сонголт нь нэг бол орос, эсхүл хятад. Ийм л түүхэн сонголт дунд монголчууд 1924 оноос 1992 он хүртэл ЗХУ-ыг бараадсан нь түүний цорын ганц гарц гаргалгаа, өвөг дээдэс маань эх орон, ирээдүй үедээ үндэсний эрх чөлөө бэлэглэсэн улс төрийн зоримог зөв шийдэл байсны үр өгөөж нь одоо ч бидэнд ач тусаа өгсөөр байна. Үүний нэгэн жишээ нь 1938/1939 оны япон, ЗХУ-ын хилийн мөргөлдөөн монголын нутаг дэвсгэр дээр хэсэгчлэн өрнөснөөр монгол дэлхийн II дайнд татагдан орж явцын дунд 1960-аад онд хятад-зөвлөлтийн харилцаа хурцдахад БНМАУ нь ЗХУ-ыг аялдан дагаж 1966 онд харилцан туслалцах гэрээнд гарын үсэг зурсны дараа ЗХУ-ын хэд хэдэн дивизийг монголд байршуулжээ. 1989 онд Бээжингийн Тянь-ань мэний талбайд болсон

⁵ Цаасан дээр бүх улс үндэстэн тэгш эрхтэй гэдэг ч үнэн хэрэг дээрээ бол нэг хэсэг нь хүчтэй том улсууд (Их хорь, их долоо, манай хоёр хөрш гүрэн энэ тэр гээд). Нөгөө хэсэг нь хүчирхэг улс орныг дагаж амьдардаг бага буурай улс үндэстнүүд байдаг. Энэ хоёр ангилал бол хамгийн түгээмэлд тооцогдоно. Яахав дээрх үндсэн ангиллын дагаварт 3 хэлбэр байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал цөөн хэдэн улс ямар нэг хэмжээнд харьцангуй бие даасан байдалтай өөрөө өөрийгөө аваад явдаг бол дөрөв дэх хэсэг нь колони, хагас колони маягтай “де факто” орнууд (1921-1946 оны БНМАУ шиг). Тав дахь нь хүн амынхаа хүнсний хангамжийг ч бэлтгэж чаддаггүй авлигад идэгдсэн сул дорой, ядуу зүдүү хөгжиж буй орнууд байдаг. Бодит байдал ийм байхад манай үе үеийн улс төрчид гэх нөхөд хэтэрхий бие тоож алсын Америк, арлын Япон, өндөр хөгжилтэй Европтой зиндаархан хоёр хөршийнхөө удирдагчдыг хэлэх хэлэхгүй үгээр хэмлэх нь байж боломгүй асуудал юм (Ш.Ц).

эсэргүүцлийн хөдөлгөөнийг хүч хэрэглэн дарсны дараа үндсэндээ социалист орнуудын холбоо задарч, ЗХУ-ын удирдагч М.С.Горбачев Бээжингийн шахалтаар монголоос цэргээ гаргаж хүйтэн дайн илааршсан нь 1990 оны монгол дахь ардчилсан хувьсгал тайван замаар өрнөх нөхцөлийг бүрдүүлсэн байдаг. Тухайлбал МоАХ-оос зохион байгуулсан өлсгөлөн, жагсаал цуглааныг хүч хэрэглэн тараахаас эрх баригч МАХН-ын төв хороо татгалзсан тул шинэ ба хуучин улс төрийн хүчнүүд “оготнын хамраас цус гаргалгүй ах дүү, аав хүүхдүүд” мэт найрсгаар тохиролцож, Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баталж, хамтарсан Засгийн газар байгуулан, Монгол Улсын анхны Ерөнхийлөгчийг сонгосноор ардчилсан хувьсгалын үйл явц бие биедээ аажуухан уусаж эцэстээ “МАНАН” болж хувирсан гэж үздэг судлаачид цөөнгүй бий.

Нэгэн жижиг кэйс гэхэд 2020 онд Д.Лхагвасүрэн, Д.Сүхболд тэргүүтэй таван зохиогч “БНМАУ-ын Үндсэн хуулийн тайлбар философи”-ийг толилуулсан нь АН, МАН-гүй Д.Сүхбаатар, Х.Чойбалсангийн ардын хувьсгалын 100 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн хувьсгалт худал домгийг алдаршуулж, хутга тавихгүй мах идэж, хундага тавихгүй архи ууж, найрлаж наадацгаах нь одоогийн ардчилсан шинэ Үндсэн хуулийн эсрэг социалист үзэл санааг агуулсан хувилбараас өөрцгүй харагдана. Тэрчлэн өмнөх ах дүү гурван Үндсэн хуулиудад орчин үеийн мэт санагдах олон эрх бий. Тухайлбал, үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх, эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн адил тэгш эрхтэй байх, ажил амралтын дээд хязгаарыг 8 цаг байхаар тогтоох зэрэг позитивист эрх зүйн хэм хэмжээг хуулиар олгосон боловч тэр нь үнэн хэрэгтээ бодит байдал дээр эдгээр эрхийг зорилгоос хамааруулан хязгаарлаж социалист төрийн зохион байгуулалтыг хөгжүүлэн бэхжүүлэх болон хөдөлмөрчдийн эрх ашигт нийцсэн тохиолдолд зөвшөөрөх агуулгатай байгаа болно.

Товчдоо бол анхны Үндсэн хууль батлагдсан 1924 оноос хойших монгол улсын түүх 1930 онд фундамент суурь нь тавигдсан Ерөнхий сайд Цэнгэлтийн Жигжиджавын засаг захиргаа – нутаг дэвсгэрийн шинэтгэлтэй салшгүй холбоотой ч өмнөх үеийн өөр хоорондоо эрс ялгаатай, нэлээд зөрчилтэй, бас ээдрээтэй төсөөллөөр дүүрэн засаг захиргаа-нутаг дэвсгэрийн онцлог үе шат хүссэн хүсээгүй 1992 оны шинэ Үндсэн хуультай шууд холбогддог.⁶

⁶ Д.Сүхбаатар. МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор, Үндэсний түүхийн музейн захирал, түүхийн ухааны доктор “Ерөнхий сайд Ц.Жигжиджавын засаг захиргаа нутаг дэвсгэрийн шинэтгэл, түүхэн ач холбогдол” илтгэл., “Тусгаар тогтнол ба Ерөнхий сайд Ц.Жигжиджавын нийгэм эдийн засгийн шинэтгэл”., Түүхийн хүрээлэн. Уб хот., 2020 он. х. 50-59 дэх тал.

II. Анхдугаар үндсэн хуулийн эргэн тойрон дахь улс төрийн шийдвэр, түүний эрх зүйн эерэг сөрөг үр дагавар

БНМАУ-ын 1924 оны Үндсэн хуульд шүүгч, шүүхийн тухай зохицуулалт огт байгаагүй. Гэхдээ 1940 болон 1960 оны Үндсэн хуульд шүүх ба прокурорын тухай бие даасан бүлэгтэй болсон ч шүүгчдийг улсын Бага хурал, хот ба аймгийн Бага хурлуудаас, хожим нь Ардын Их хурал болон аймаг, хотын депутатуудын хурлаас цөөн жилийн хугацаагаар сонгож байжээ. Мөн дээд шүүх нь Ардын Их Хурал ба түүний Тэргүүлэгчдэд ажлаа хариуцан тайлагнах үүрэгтэй байхаар зохицуулсан байдаг. Ийм шүүх хэнд үйлчилсээр ирсэн нь ойлгомжтой хэрэг. Ялангуяа “прокурор”-чууд “энхрий хайрт нам”-д үнэнч байх нь шударга ёс ялан дийлэх, зөрчигдсөн эрх сэргээн эдлүүлэх тухай асуудлаас илүү чухалд тавигдаж байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Одоо ч гэсэн олигтой шинэчлэгдэж чадахгүй байгаа прокурорын хатуу төвлөрлийг ардчилах шаардлага зүй ёсоор тавигдсаар байна.

Монгол Улс 1924 онд Үндсэн хуулиа батлаад зогсохгүй олон улсын хэм хэмжээ нийцсэн бие даасан, бүрэн эрхт (независимость-independent) улс болохоо харуулсан хууль ёсны баримт бичиг мөн хэдий ч анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах үйл явц, тунхагласан улс төрийн зорилтууд нь ЗХУ-ын Коммунист намын хяналт зааварчилга дор явагдсаныг хэн ч үгүйсгэж чадахгүй. Тэрчлэн 1924 оны Үндсэн хуулийн мөн адил 1940, 1960 оны Үндсэн хууль нь Москвагийн заавраар бичигдсэн “ах дүү” Үндсэн хуулиудын хэвшмэл загвар гэдгийг доорх зүйл заалт бэлхнээ гэрчилдэг. Үүнд:

А. 1924 оны Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилт бол хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр устгаж, улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийлүүлж, шинэ ёсны Бүгд Найрамдах Улсын үндсэн тулгуурыг бататган бэхжүүлнэ” гэжээ.

Б. 1940 оны Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд: Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилт бол эзэрхэг түрэмгийг ба феодалын дарлалыг устгасан цаашид нийгэм журамд давшин орохын учир улс орноо хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангах бүхий хөдөлмөрчин /малчин, ажилчин, оюутан/ ардын тусгаар тогтносон улс мөн болно

В. 1960 оны Үндсэн хуульд Монгол, ЗХУ-ын нягт харилцаа, хараат байдлыг удаа дараа онцолсон байдаг. Энэхүү үзэл суртлын чиг баримжаа нь ЗСБНХУ, БНХАУ-ын хооронд үүссэн геополитикийн хүнд нөхцөлд Монголын төрт ёс бий болох боломжийг нээсэн хэдий ч төр, нийгмийн тогтолцооны талаарх монголчуудын үзэл санааны үр

дүн байгаагүй.

Г. Гагцхүү 1992 оны Үндсэн хууль л олон улсын экспертүүдийн оролцоотой ч гэсэн монголчуудын өөрсдийн эрэл хайгуул, зөвшөөрөх эсэх тухай зүй ёсны асуудал, сонгох сонгогдох эрх харьцангуй баталгаажсан 1992 оны шинэ Үндсэн хуулийг баталж мөрдсөн байдаг. Ард түмэн үндсэн хуульд өөрийн эрхээ, нөхцөл байдлаа мэддэг байх ёстой, эс тэгвээс үндсэн хуультай боловч, энэ нь ямар ч ач холбогдолгүй, үнэ цэнгүй байх нь бий.⁷

Энэ цаг үед доктор Б.Ренчин, яруу найрагч Р.Чойном хоёрын шүүмжлэлтэй хандлагаас өөр үзэл санаа санал болгож байсан түүхгүйг хүлээн зөвшөөрвөл зохино. Төрийг иргэн хүнтэй чацуулах (гуманизм-humanism) эрх чөлөөний үзлийг ойлгосон, ойлгуулсан зохиол, бүтээл одоо ч гараагүй. Харин МАХН доторх өөр бодолтнууд (сэхээтний төөрөгдөл, Лоохууз, Сүрмаажав гэх өөр үзэлтнүүд)-ыг шууд нухчин дарсан талаарх кейс бүхий олон боть ном бий (Хэлмэгдэгсдийн холбооны тэргүүн улс төр судлаач Дашнамжилын Цогтбаатарын он дараалсан удаа дараагийн эрдэм шинжилгээний өгүүлэл, мэдээллүүдээс харж болно. Ш.Ц).

- *Ардчиллын буянаар ил тод* болчихоод буй өөр нэгэн “тольдмол” үйл явц бол **1921-1960-аад оны үеийн Ерөнхий сайдуудын үйлдэл, эс үйлдэхүй юм**: а) 1921-1924 онд төр засаг, улс орноо төвхнүүлэх үйл явц (үзэл бодлын зөрүүгээс 1911,1921 оны үндэсний удирдагчдыг хэлмэгдүүлсэн асуудал); б) 1925-1929 онд “хар феодалууд” буюу тайж язгууртнуудтай тооцоо хийсэн “цэвэрлэгээ”-ний жил (Ерөнхий сайд А.Амар, Цэргийн яамны сайд Х.Чойбалсан); в) 1930-1934 он бол их аллага хядлагаас харьцангуй хөндийрсөн бүтээн байгуулалтын гэж хэлж болох үүлэн чөлөөний он тоолол байдаг (Ерөнхий сайд Ц.Жигжиджав, П.Гэндэн); г) 1935-1939 он “шар феодал”, Японы тагнуул, хувьсгалын эсэргүүтэй тэмцэх их цэвэрлэгээний он жил (Ерөнхий сайд А.Амар, Дотоод яамны сайд Х.Чойбалсан. Олон хүний амь нас хөнөөсөн хэргээр А.Амар ЗХУ-д цаазлагдаж, Х.Чойбалсан ерөнхий сайдаар томилогдсон байна); д) 1939-1946 онд хилс хэрэгт цэргийнхэн өртжээ (Х.Чойбалсан+Ю.Цэдэнбал); е) Дэлхийн II дайны дараах буюу 1950-аад оноос хойших социалист бүтээн байгуулалт. Энд 1961 онд НҮБ БНМАУ-ыг бүрэн эрхт гишүүнээр хүлээн авсан түүхт үйл явц зүй ёсоор орно (Ю.Цэдэнбал, Ж:Батмөнх); ж) 1992 оноос ардчилсан Үндсэн хуулийг хэрэгжүүлэх улс төрийн ардчилсан дэглэм бүхий иргэний нийгмийг төлөвшүүлэхийн төлөө он жил гэж Монгол Улсын сүүлийн 30 гаруй жилийн түүхэн үйл явцыг ерөнхийд нь тоймлон үзэж болохоор байна;

⁷ *Hegel. 2015. х 1011-1012 дахь тал.* Оливер Корфф., Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн түүхийн товчоон. Уб., 2024.

Энэ хүрээнд 1921-1990-ээд онд улс эх орныхоо төлөө зүтгэж явсан Ерөнхий сайдуудын хувь заяаны нийтлэг хэв шинж нь бараг бүгдээрээ адилхан гунигт түүх өгүүлнэ. Тухайлбал, МАХН (одоогийн МАН) эхлээд заавал нэг удирдагч төрүүлж, тэр удирдагчаа тахин шүтүүлнэ, зургийг нь албан газар, айл гэрийн хойморт залж дуу шүлэг, жүжиг зохиолд оруулж төрийн албан хаагчид шагшин магтана.

Эцэст нь буруутгана, гутаана, егүүтгэнэ. Тэр бүү хэл эсэргүүцэн шүүмжилбэл үр хүүхдээр нь эцэг эхийг нь, шавь нараар нь багш нарыг нь, тогооч жолооч нараар нь эздийг нь эсэргүү болгож дуусгадаг энэ увайгүй түүх одоо ч хэлбэр дүрсээ ардчилалд хуурмаглан нийцүүлэх төдий хэмжээнд буйг энд товч хөндөхөд илүүдэх юун (Д.Сүхбаатар, Х.Чойбалсан, А.Амар, П.Гэндэн, Ц.Жигжиджав, Ю.Цэдэнбал, Н.Энхбаяр, Ц.Элбэгдорж, М.Энхболд, Ч.Сайханбилэг гээд цааш урт цуваа үргэлжилнэ).

Монголын ерөнхий сайд нар “цаазлагдсан”, “эх орноосоо урвасан”, “хорлогдсон”, “хятадын засгийн газраас тавигдсан”, “улсаа худалддаг”, “гарын буу осолдсон”, “хувьсгалын эсэргүү”, “оросын тагнуул”, “японы тагнуул”, КГБ-ын “туршуул”, “хятадын тагнуул”, “ардиргэдээ гуч дөчин мянгаар нь хоморголон устгадаг”, “авлигаддаг”, “албан тушаалын гэмт хэрэг үйлддэг”; “гадаад руу зугтан гардаг”. Тэрчлэн Үндсэн хуулийн бус аргаар эрүүл мэнд, өөрийн хүсэлт гэх нэрэн дор огцорч, хулгайлсан эд хөрөнгөө гадаадад байршуулж, дараа нь хуулийн хулгай (вор закон) хийж бусдыг турхирч уруу татдаг гэх зэргээр Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хүнд байж боломгүй харш нэр хоч зүүгджээ. Үүнд тун ноцтой дүгнэлт хийж, чухам хэн нь ямар гавьяа зүтгэлтэй, алдаа завхрал, урвалт шарвалт, хэрэг төвөг үйлдсэн тухай тэр нь үндсэн хуулийн болон холбогдох материаллаг хуулийн ямар зүйл заалт зөрчсөнийг нийтэд ил тод болгохыг амьдрал шаардсаар байна.⁸

⁸ 1. Би хэн бэ? Бид хэн бэ?; Бидний түүхэн муу муухай ужиг эмгэг юу вэ?; Бидний сайн сайхан нь юу вэ? (Танин мэдэхүйн ерөнхий аналитик);

2. Бид хаанаас ирсэн бэ? (түүхэн гүн ухааны асуудал);

3. **Бид хаашаа явж, юунд зорьж тэмүүлж байна вэ?** (ирээдүй судлал, үндэсний үзэл санааны асуудал); дээрх нийгмийн үзэл баримтлал, үндэсний философийн 3 цогц асуудал хариулт нэхэж байна. Эдгээр асуудалд монгол хүн бүр хариулт өгч чадаж баймааж нь бид нийгмийн төөрөгдөл (Инийтийн тэнэгрэл)-өөсөө салж чадна, бас монгол үндэстний үзэл санааны өөрийн гэсэн концепцтэй болно. Даанч үүнийг манай сэхээтнүүд сонирхохгүй байгаа нь улс үндэстэнд нүүрлэсэн аюулын харанга гэхэд хилсдэхгүй. Яагаад бид ийм байдалд орчихоод байна вэ гэвэл монголчууд үндэсний гэх үзэл санааны философигүй, улс төрийн намууд нь гэрэлт ирээдүй өөд нэгэн зүгт нийтээр дагуулан тэмүүлэх алс хэтийн зорилго зорилт буюу “идеологи” ба “идеал”-гүй байгаагийнх юм. Энэ нь ямар нэг тодорхой онол арга зүйгүй хөгжил хэмээх зорилтот том нийлмэл цогц Засгийн газрын хөтөлбөрийг одоо болж буй мэтээр хийсвэрлэж, ололт, ахиц, амжилт, дэвшилд хүргэх прагматик бодит үйл явцыг шууд алгасч капитализмыг алгассан

Үүнээс үүдэн “буг” ч юм шиг “бурхан” ч юм шиг хоёр дүртэй марзан улс төрчид монголд ар араасаа төрөн гарч энэ нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн нэг ёсны улс төрийн бодлогын алдаа завхралыг цаг алдалгүй засаж залруулах шаардлага тулгамдсан асуудлын нэг мөн гэж үзэж байна.

III. Шинэ үндсэн хуулийн хэрэгжилт ба үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийг тойрсон өнөө цагийн зарим “ПРОБЛЕМ”

Шинэ Үндсэн хуулийг хэрэглээний хувьд улс төрийн ардчилсан дэглэмд суурилсан удирдлага зохион байгуулалтыг төлөвшүүлэхийн төлөөх үйл ажиллагаа гэж ерөнхийд нь тоймлон үзэж болно. Товчдоо бол 1992 оны шинэ Үндсэн хууль нь нийгэм соёл, эдийн засаг, улс төр судлалын бүх төрлийн судалгаа, хууль зүйн шинжилгээ түүнийг тойрч хийгдсэн ард түмний гэж хэлж болох гайхамшигтай бүтээл гэдгийг хэлэхэд нэн таатай байна (үүний задаргааг хэлбэл олон хуудас материал болно. *Ш.Ц*).

Харамсалтай нь 1999, 2000, 2019, 2022, 2023 онуудад жил дараалан хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулах замаар шинэ Үндсэн хууль руугаа уулгалан дайрцгаасан үр дагавар нь илэрхий судалгаа муутай, дур зоргын шийдвэр байсныг анхны Ерөнхийлөгч П.Очирбат тэргүүтэй цөөнгүй судлаачид хүчтэй эсэргүүцсээр ирснийг гүнзгийрүүлэн судалж үзэх шаардлагатай байгаа болно.

Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт /цаашид “ҮХНӨ” гэх/ оруулахдаа тулбал үзэл баримтлал болгодог маш нарийн горим ба процедур ажиллагаа, хатуу дэг журам нь ердийн хуультай харьцуулшгүй өндөр (“критери”) шалгууртай, илүү нарийвчилсан бөгөөд тусгайлсан журмаар хэрэгжих, хэн нэг эрх мэдэлтний ямар ч сэтгэлийн хөөрөл эмоцигүй судалгаа шинжилгээний бодит үр дүнд тулгуурлахад түүний хууль зүйн шинжлэх ухааны утга учир оршдог. Жишээ нь Япон улс хэдэн зуун жилийн түүхэндээ Үндсэн хуульдаа өөрчлөлт бараг хийгээгүй, харин цөөн тооны нэмэлт л оруулсан байдаг. АНУ-д Үндсэн хуульд гар хүрэх гэсэн 10 мянга гаруй удаагийн санаархал байсан ч нэг нэмэлтийг дунджаар зургаан сараас гурван жилийн хугацаанд хэлэлцэж байж шийдэхдээ ихэвчлэн буцаасан байна.

Тэрчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн §68.1 дэх заалт ёсоор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль

урьдынхаа том алдааг дахин давтаж буй хэрэг юм. Үүн дээр өнөөгийн манай монгол дарга даамлуудын атаархуу, бялдууч, сагсуу ойворгон, бүдүүлэг давилуун авир араншин ихээхэн нэрмээс болж буй гажуудлыг нийтээр засаж залруулах асуудал хариулт нэхээд удаж байна. Эдгээр нь ГЭМ судлалын язгуур философи болой (Ш.Ц).

санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах хэдий ч УИХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг зөвхөн Үндсэн хуулийн цэц өргөн мэдүүлэх эрхтэй болно. Мөн уг асуудал нь Ард нийтийн санал асуулгын хэмжээнд зохицуулагдах эрэмбэтэй. Гэтэл дээрх заалтыг манай парламент 2019, 2022, 2023 онд эсрэгээр нь хэрэглэсэн байдаг.⁹

Тухайлбал 1992 оны шинэ Үндсэн хуульд нийтдээ 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа “миний эрх багадаж байна, тэрний эрх ихдэж байна”, “бидний тоо цөөдөж байна, УИХ-ын гишүүдийн тоог олон болгоод өгвөл улс орны хөгжлийг цэнгэлийн манлайд хүргэнэ” гэх мэт албан тушаал хөөцөлдсөн дур зоргын авир араншин зонхилсон, хөнгөн хуумгай, яаруу сандруу субъектив хандлагаар Монголын ард түмний язгуур үнэт зүйл болсон Үндсэн хуульд хайхрамжгүй хандсан нүглээ наминчлах хэрэгтэй.

Товчдоо бол “Монгол Улсын Үндсэн хууль” гэж яг оноож, чиглэж судалсан судалгаа Б.Чимид докторын судалгаа шинжилгээг эс тооцвол харьцангуй бага. Байгаа ганц хоёр нь гадаад дотоод хэсэг “нөхөд” үгсэн нийтлүүлэх замаар улс төрийн намын дарга нарын захиалга, нэр бүхий эрх баригчдын хүсэл сонирхолд тааруулах маягийн өнгө төрхтэй хүндэтгэлгүй судалгаа шинжилгээний ажил, толилуул (хэвлүүлсэн)-саар ирснийг хүлээн зөвшөөрвөл зохино.

Манай залуу судлаачдад хандаж хэлэхэд африк, америк, ази, европ гээд “дэлхий” ярьж агаарт хөвж хөөсрөх маягтай бид олон жил явлаа. Одоо газардаж “Монгол Улсын” гэх тодотголтой Үндсэн хуулийг дагнаж судлах чухал болжээ гэдгийг хэлмээр байна.¹⁰

ҮХНӨ-ийг аль нэг нам бүлэг, аль эсвэл түүнийг санаачилсан марзан этгээдүүд өөрсдөө УИХ-д өргөн барьж, улмаар өөрсдөө хэлэлцүүлэгт нь оролцож, тэр бүү хэл өөрсдөө баталсан ийм завхрал ардчилсан бусад улс орны Үндсэн хуулийн түүхэнд одоогоор тэмдэглэгдээгүй байна.

ҮХНӨ-г хийхдээ хүрвэл зарчим болгодог онол, арга зүйн гол

⁹ Энэ тухай алдарт Б.Чимид багшийн “Үндсэн хуульд гар хүрсэн хүн өөдөлдөггүй” гэж хэлснээр гадаад дотоодын холбогдох этгээдүүд ёс юм шиг хэл ам, хэрэг төвөгт орооцолдож, эрх мэдэл, ажил албан тушаалаасаа салсан байдгийг судлаад үзвэл сургамжтай л кейс байх болов уу (Ш.Ц).

¹⁰ Профессор Б.Чимид “Манай залуус та нар “Монгол Улс” гэдэг хоёрхон үгийг санаатай ба санамсаргүйгээр хасч дэлхий ярьж ази, африк, америк гээд үзүүрийг нь тасдаж ёзоорыг нь ухаад хаячихсан үндэс мөчиргүй хожуул модны тухай дэмийрч мэдэмхийрэхийн оронд “Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй” гэдэг үр углуурга, навч мөчиртэй ургаж буй амьд ногоон модны тухай хичээл зааж, судалгаа хийж, доктор хамгаалж байж сая жинхэнэ монгол эх сурвалж, монгол хөрсний хууль, монгол эрдэм ном бүтээгдэнэ” хэмээн нэгэн докторантын хамгаалалт дээр хэлсэн үгийг энд давхар ишлэв (Ш.Ц).

хоёр шаардлага байдаг. Нэг нь субъектив хандлага. Нөгөө нь объектив бодит шаардлага. Субъектив хандлага нь аль ч парламентад илэрч байдаг хэдий ч эцсийн дүндээ хэн нэг хүний, их сайндаа аль нэг бүлэг этгээд хувийн ашиг сонирхлоо илэрхийлсэн хувь атгаг санал, бодол төдий зүйл байх нь олонтаа байдаг тул түүнийг ҮХНӨ-д ашигладаггүй, бас авч хэлэлцдэггүй хатуу үзэл баримтлал бидний дагаж дуурайдаг ардчилсан улс орнуудад үйлчилсээр иржээ.

Харин объектив бодит шаардлага нь голдуу эдийн засгийн харилцааг өөрчлөх зайлшгүй “проблем”-ын шийдэл байдаг. Жишээ нь Монгол Улс 1920-оод оны үеийнх шигээ өр зээлэнд баригдлаа. Шулж мөлжих, амар хялбараар мөнгөжих, хөрөнгөжих, бэлэнчлэх, мөнгө шүтэх үзэлд хэтэрхий автагдлаа.

Уул уурхайг эдийн засгийн гол түшиц хэмээн өргөмжилж, уламжлалт хөдөө аж ахуйн салбараа орхигдуулж түүний бүтээгдэхүүн үнэгүйдлээ. Гэтэл уул уурхай эцсийн эцэст энд тэндгүй ухсан нүх, овоолсон шороо, хатсан булаг шанд, хоцрогдсон техник үлдээдэг нь нууц биш болжээ. Ийм асуудлаар ҮХНӨ оруулах гэж байгаа бол объектив бодит шалтгаан гэж үзнэ.

Бас мөнгө хүлээгчид, хулгайчид, тонуулчид, луйварчид, янз бүрийн хуйвалдаан зохион байгуулагчид хүн амын ихэнхийг бүлэглэн мөлжиж иргэд олон нийтийг ядууруулан туйлдуулж байгааг өөрчилж гэж байгаа бол уг асуудал нь өөрөө нийгмийнх ч гэлээ ҮХНӨ хийх объектив бодит шалтгаан болох жишээтэй. Тухайлбал, уул уурхайгаар явах уу, уламжлалт хөдөө аж ахуй-мал аж ахуйгаа хөгжлийн гол концепц болгох уу гэдэг ч юм уу.¹¹

Энэ бүгдээс дүгнэлт хийж “ардчилсан улс төрийн дэглэм”¹²-ийн критери шалгуур талаас нь үзвэл Монгол Улсын 1924-1960 оны Үндсэн хуульд тусгагдсан улс төрийн сонгох ба сонгогдох эрх нь нэгэнт тогтсон нэг намын тогтолцоон дахь бүх нийтийн санал

¹¹ Ш.Цогтоо Үндсэн хуульд “Зөвлөлдөх санал асуулга” гэсэн үг байхгүй, харин Ард нийтийн санал асуулга хэмээх зүйл заалт л бий. Өдрийн сонин. 2023.01.31 №02 (7141).

¹² Ардчилал гэдэг нь нийгэм үү? эсхүл улс төрийн дэглэм үү? Авторитар, тоталитар, ардчилсан, цэргийн гэх улс төрийн дэглэм оршсоор ирсэн байх боловч эдгээрийн дотроос шударга сонгуулийг өөрийн амин сүнс болгосон ардчилал нь хүн бүрийн санал адил үр нөлөөтэй байх тэгш эрхийн зарчимд суурилдаг бол орчин үеийн эдийн засгийн харилцааны голлох арга механизм болох “либерал” ба “неолиберал” хандлага нь баячуудын хангалуун байдлыг улам баталгаатай болгохын тулд ардчиллыг хязгаарлах шаардлагатай хүссэн хүсээгүй тулгардаг. Товчдоо бол чөлөөт зохицуулалтгүй эдийн засгийн системд бүтээгдсэн баялаг үргэлж тэгш бус хуваарилагддаг нь бараг байгалийн хууль. Бид ийм зөрчилтэй эсрэг тэсрэг харилцааг бараг хүчээр нөхцөлдүүлж байгаа нь манай хөгжлийн замналын сонголтод асуудал буйг илтгэдэг (Ш.Ц).

хураалтын шинж чанартай байсан бөгөөд иргэд өөр өөрсдийн улс төрийн чиг баримжааны жинхэнэ сонголт хийж чаддаггүй байсныг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Харин 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр бол Үндэсний эрх чөлөөний тэмцлийн төлөө өдөр юм. Учир нь Чин улсын 200 гаруй жилийн боолчлолын гинжнээс салахаас өөр чухал үнэт зүйл монголчуудад байгаагүй. Учир нь 1911 онд Үндэсний эрх чөлөөний тэмцэл өрнөөгүй бол “1921” он байтугай өнөөдрийн ардчилсан Монгол Улс байхгүй байх тун ч өндөр нигууртайг огтхон ч эргэлзэхгүйгээр хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.

Товчдоо бол ХХ зууны эхээр аз болж 1911 онд Чин улс, 1917 онд хаант орос гэсэн хоёр том импери задран унаснаар үндэстнийхээ хувьд мөхөл сэхлийн ирмэг дээр тогтож ядаж байсан монголчуудад тусгаар тогтнолоо дахин сэргээх боломж олдсон юм. Бүр тодорхой хэлбэл 1921-1924 онд залуу ЗХУ, коминтернийн хяналт зааварчилга дор монголчууд анхны Үндсэн хуулиа баталж, БНМАУ-ыг зарлан тунхагласан нь өнөөгийн ардчилсан Монгол Улсын залгамж холбоо болж тэр үеийн түүхэн ач холбогдол одоо ч алдагдаагүй хэвээр байна.¹³

Ийнхүү монголын анхдугаар Үндсэн хууль, тэрчлэн 1940, 1960 оны ах дүү зорилго нэгт Үндсэн хуулиудын уялдаа холбоог улс төр судлал, эрх зүйн онол, философи, түүх судлалын үүднээс чадан ядан авч үзсэн хууль зүйн аналитик товчдоо ийм буюу. Нийгмийн удирдлагын дээд түвшинд нийтийн ашиг сонирхолд хохиролд учруулах гэмт хэргүүд байрладаг. Харин доод түвшинд ихэвчлэн хувийн явцуу эрх, эрх чөлөөг хөндсөн зөрчлүүд хөндөгддөг” хэмээн 200 гаруй жилийн өмнө алдарт Чезаре Беккариа айлдсан¹⁴ нь өнөөдөр ч хэвээр байна.

¹³ С.Нарангэрэл. Анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл, Төрийн ордон., 2024 он.

¹⁴ Чезаре Беккариа “хууль зүйн классик төдийгүй Европын соёлын өв сан дахь хосгүй эрдэнэ хэмээн нэрлэгдсэн” “Гэмт хэрэг ба ялын тухай” номын нийтийн эрх зүйн зохицуулалтын бүлэг, орч. Г.Эрдэнэбат, Уб., 2014 он.

[Ном зүй]

Д.Сүхбаатар. Ерөнхий сайд Ц.Жигжиджавын засаг захиргаа нутаг дэвсгэрийн шинэтгэл, түүхэн ач холбогдол” илтгэл. “Тусгаар тогтнол ба Ерөнхий сайд Ц.Жигжиджавын нийгэм эдийн засгийн шинэтгэл”, Түүхийн хүрээлэн. Уб хот., 2020 он.

З.Лонжид, Т.Лхагваа. Тусгаар тогтнол ба Монгол Улс дахь анхны нийгэм эдийн засгийн шинэтгэл: Ерөнхий сайд Ц.Жигжиджавын гүйцэтгэсэн түүхэн үүрэг. Уб., 2021 он

Оливер Корфф, Ц.Сарантуяа. Үндсэн хуулийн түүхийн товчоон. Уб., 2024.

С.Нарангэрэл. Анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл, Төрийн ордон. 2024 он.

Ш.Цогтоо. Үндсэн хуульд “Зөвлөлдөх санал асуулга” гэсэн үг байхгүй, харин Ард нийтийн санал асуулга хэмээх зүйл заалт л бий. Өдрийн сонин. 2023.01.31 №02 (7141).

Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. (орч. Г.Эрдэнэбат). Уб., 2014 он.

Negel. 2015.

[Abstract]

**The First Constitution and the Legal Analysis
Accompanying its Political Decision**

Shar Tsogtoo

Doctor of Laws (Ph.D.).

*Professor at the Department of Public Law,
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

It is important to emphasize that a constitution is a unique subject of study that must be interpreted through a complex interdisciplinary framework, encompassing political science, linguistics, philosophy, history, and even mathematics. In this light, analyzing the legal implications of the First Constitution requires not only a legal approach but also an understanding of the ideological conflicts of the time - including socialist, feudal, autocratic, totalitarian political regimes, and democratic and liberal philosophies. At the beginning of the 20th century, the collapse of two major empires - the Qing dynasty in China in 1912 and the Russian Empire in 1917 - presented the Mongolian people, who were then teetering on the edge of national extinction, with a rare opportunity to restore their independence. More specifically, under the influence and guidance of the nascent Soviet Union and the Comintern between 1921 and 1924, Mongolia adopted its first Constitution and proclaimed the establishment of the Mongolian People's Republic. This act laid the foundation for statehood, serving as a historical predecessor to modern democratic Mongolia - a legacy whose importance remains significant to this day. From the perspective of the criteria for a democratic political regime, it must be acknowledged that the right to vote and be elected, as enshrined in the Constitutions of Mongolia from 1924 to 1960, functioned within the framework of a single-party system and thus resembled a universal referendum, lacking genuine political choice for citizens. In contrast, the 1992 Constitution can be evaluated, from a legal-analytical perspective, as a foundational instrument aimed at establishing and institutionalizing a political system based on democratic governance.

[Keywords]

The State, the Nation, Democratic Political Regime, Liberalism, Neoliberalism, "Ideology", "Ideal", "*De facto*", "*De jure*" processes, "Fraternal" Constitutions, contradictions between Constitutions.